



**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлаас Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг 2020 оны 11 сарын 13-ны өдөр баталсан ба 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын “Орон нутгийн хөгжил” хэсгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжих үе шатанд “тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн байна” гэсэн үр дүнд хүрэхээр тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2050 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн “Тогтвортой хөдөө аж ахуй” хэсгийн Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлэх зорилтын хүрээнд “тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ”, “усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, төрөлжүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх зорилгоор тариалангийн бүс нутгийг энэ хуульд заасны дагуу тогтоож болно.”, 17.5 дахь хэсэгт “Тариалангийн бүс нутагт суурин болон хагас суурин эрчимжсэн мал аж ахуйг тусгайлсан бэлчээрт эрхэлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газраас 2018 онд баталсан "Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай" 131 дүгээр тогтоолын 2.1-т "орон нутгийн хөгжлийн бодлого, аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, төрөлжүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослон хөгжүүлэх ажлыг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд хамрагдсан аймаг, сум бүр төлөвлөгөөтэй, үе шаттайгаар зохион байгуулах", 2.2-т заасан "тариалангийн бүс нутагт мал аж ахуй эрхэлж байгаа малчдын малыг бэлчээр, ус бүхий нутагт шилжүүлэх, мал сүргээ төрөлжүүлэх, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийж, бүх талын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах" гэж тус тус заасан.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулж, хуулийн хүрээнд нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээг 0-2000 төгрөг багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтоож, малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно гэж хуульчилсан. Татварын хэмжээг үл харгалзан газар тариалангийн бүс нутагт уламжлалт бэлчээрийн мал сүргийн тоо өсөж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн талбайд мал ихээр орж тариалангийн талбайн хөрсний үржил шимийг бууруулах, элэгдэл эвдрэл үүсгэх, тариалангийн технологи нэвтрүүлэх боломжийг алдагдуулан үр тариа, хүнсний ногооны ургацад сөргөөр нөлөөлж, улмаар малчид тариаланчдын хооронд зөрчил үүсгэн, хохирол учруулсаар байна.

Иймд тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалж, элэгдэл эвдрэлийг бууруулж, технологи нэвтрүүлэн, тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой, эрсдэлгүй явуулж, хүн амыг хүнсний ногоогоор, мал сүргийг нэмэгдэл тэжээлээр, эрчимжсэн мал аж ахуйг тэжээлээр хангах зорилгоор Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик шаардлага

Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжил нь малын тэжээлийн үндсэн эх үүсвэр байгалийн бэлчээр, хадлангаас шууд хамааралтай юм. Манай улсын байгалийн бэлчээр, хадлан нь 2019 оны байдлаар Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 72.4%, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 97.6%-ийг тус тус эзэлж байгаа ба бэлчээрийн нийт талбай 1964 оныхоос 7.7 хувь буюу 9.4 сая га-гаар буурсны дээр Монгол улсын нийт бэлчээрийн 226% буюу 25.5 сая га бэлчээр доройтоод байна. Монгол Улсын бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны зураг, тайлангаас үзэхэд нийт доройтсон бэлчээрийн 10.3 сая га (35.8%) нь бага зэрэг, 12.6 сая га нь (49.5%) дунд зэрэг, 3.7 сая га (14.6%) нь хүчтэй доройтсон байна.

Харин дунд зэрэг болон хүчтэй доройтсон бэлчээр нь нийт доройтсон бэлчээрийн 50.7%- 73.6%-ийг эзэлж, эдгээр бэлчээр дэх ургамлын зүйлийн тоо эрс цөөрч, малд идэгдэх ургамлын ургац буурч, байгалийн аясаар нөхөн сэргэх чадвараа алдсан, ялангуяа хүчтэй доройтсон бэлчээрийн ургамалжил нь экологийн босго даван өөрчлөгдсөн байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын нийт бэлчээрийн 14.4% буюу 16.3 сая га бэлчээр хүчтэй болон дунд зэрэг доройтсон бөгөөд

эдгээрийг уур амьсгал өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд малын хөлөөс чөлөөлөх, бэлчээр сэлгэх зэрэг энгийн аргаар сэргээх боломж туйлын хязгаарлагдмал байна.

Тариалангийн бүс нутгийн үйл ажиллагаанд уламжлалт малаас гадна уур амьсгалын даяарчилсан өөрчлөлт хүчтэй нөлөөлж, эдгээр хүчин зүйлийн хавсарсан нөлөөллөөс үүдэн үр тариа 2019 онд 433.3 мянган тонн байсан бол 2020 онд 430.3 мянган тонн болж 3.0 мянган тонноор ургац буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Ийнхүү тариалангийн бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлд мал орсноор ургац буурах бэлчээрийн тэжээлийн нөөцийг хомсдуулж, улмаар малчид, тариаланчдын хооронд үл ойлголцол үүсгэх нөхцлийг бүрдүүлж, тариалангийн болон малын тэжээлийн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж байна. Мөн нэг толгой малд ногдуулах албан татварын хэмжээг сум бүр харилцан адилгүй тогтоож байгаа нь тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхэлж, уламжлалт бэлчээрийн мал тоо тогтвортой буурч, газар тариалангийн үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шалтгаан болж чадахгүй байна. Тухайлбал: Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 1 дүгээр сарын 11-ний өдрийн Б/01 тоот тушаалаар Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг байгуулж, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Мөн малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ногдуулах албан татварын хэмжээг 14 сум Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн баталж, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу сум бүр малын төрөл тус бүрд 1 толгой малд ногдуулах татварын хэмжээг 0-2000 төгрөгт багтаан харилцан адилгүй тогтоон баталж, тус аймгийн тариалангийн бүс нутагт хамаарах сумдын 1.8 сая толгой малаас нийт 2.8 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлж, бүс нутгийн онцлогт тохирсон үр үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн мэргэжлийн байгууллага, судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэн судлаачдын олон жилийн хөдөлмөрийн үр дүнд манай улсад үндэсний 24 төрлийн сортын үр үйлдвэрлэн, баталгаажуулсан бөгөөд цаашид нөөцийг нэмэгдүүлэх шаардлага бий болоод байна. Газар тариалангийн бүс нутагт бэлчээрийн мал аж ахуйг өсгөн үржүүлж байгаагаас тариалангийн талбайд мал орсноор тариалангийн талбайн хөрсний үржил шимийг бууруулах, элэгдэл эвдрэл үүсгэх, тариалангийн технологи нэвтрүүлэх боломжийг алдагдуулан үр тариа, хүнсний ногооны ургацад сөргөөр нөлөөлж, улмаар малчид тариаланчдын хооронд зөрчил үүсгэж, хохирол учруулж, тариаланчдын олон жилийн ажлын үр дүнг унагаж, хүн амын хүнсний ногоо, малын нэмэгдэл тэжээлийн хангамжийг бууруулж байна.

Иймээс Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулж тариалангийн талбайн хөрсний үржил шимийг алдагдуулахгүй байх, элэгдэл эвдрэлийг үүсгэхгүйгээр шинэ технологи нэвтрүүлэн, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж, хүн амыг хүнсний ногоогоор, мал сүргийг нэмэгдэл тэжээлээр, эрчимжсэн мал аж ахуйг тэжээлээр хангах, газар тариалангийн бүс нутагт мал аж ахуй эрхэлж байгаа малчдын малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг нэмэх замаар уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж, түүний генетик нөөцийг бүрэн ашиглах, хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх шаардлага бий болж байна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тариалангийн бүс нутаг дахь нэг малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн дараах асуудлуудыг шийдвэрлэх боломж бүрдэнэ.

1.Татварын хэмжээг үл харгалзан малын тоо өсөж, газар тариалангийн бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн талбайд мал орж үр тариа, хүнсний ногооны ургацад хохирол учруулах, түүнчлэн малчид, тариаланчдын хооронд зөрчил үүсэх нөхцөл байхгүй болно.

2.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулснаар тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалж, элэгдэл эвдрэлийг бууруулан, технологи нэвтрүүлж, тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой, эрсдэлгүй явуулж, хүн амыг хүний ногоогоор, мал сүргийг нэмэгдэл тэжээлээр, эрчимжсэн мал аж ахуйг тэжээлээр хангах газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг тогтвортой хөгжүүлнэ. 2020 онд газар тариалангийн салбарт үр тариа 430.3 мянган тонн, төмс 244.3 мянган тонн, хүнсний ногоо 121.2 мянган тонн, тэжээлийн ургамал 182.1 мянган тонн, техникийн ургамал 22.6 мянган тонныг хураан авч, 1.2 сая тонн хадлан, 42.2 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оноос төмс 52.1 (27.1%) мянган тонн, хүнсний ногоо 21.7 (21.8%) мянган тонн, тэжээлийн ургамал 61.0 (50.4%) мянган тонноор тус тус өссөн бол үр тариа 3.0 (0.7%) мянган тонноор буурсан үзүүлэлттэй гарсан. 2021 оны ургац хураалтын дүнгээр нийтдээ 605.6 мянган тонн үр тариа, үүнээс 567.0 мянган тонн улаанбуудай, 181.5 мянган тонн төмс, 118.6 мянган тонн хүнсний ногоо, 302.5 мянган тонн тэжээлийн ургамал, 53.6 мянган тонн тосны ургамал тус тус хураан аваад байна. Манай улсад нийт 30 тэжээлийн үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас улирлын чанартай 8, байнгын 22 үйлдвэр үйл ажиллагаа явуулж, үйлдвэрлэлийн хэмжээ 95.0 мян.тн хүчит тэжээл үйлдвэрлэж, дотоодын хангамжийн 41.0 %-ийг бүрдүүлж байна.

3.Дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи бүхий эрчимжсэн мал аж ахуйг газар тариалангийн бүс нутагт хослуулан хөгжүүлж, нөөцийг тогтвортой, зохистой ашиглан, ажлын байрыг тогтвортой хадгалах боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр

боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөл боловсруулсантай холбогдуулан шинээр боловсруулах хууль тогтоомж байхгүй болно.

---ooOoo---